

**ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2019 оны 04 сарын 15

**ЧАНДМАНЬ СУМЫН ТӨВИЙН ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙХ ТЕНДЕРИЙН БАРИМТ  
БИЧИГ**

**Төслийн нэр: СУМЫН ТӨВИЙН ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙХ**

**Төслийн дугаар: ТШ-2019/АЖИЛ-01**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.04.15

**[ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[ЧАНДМАНЬ СУМЫН ТӨВИЙН ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙХ]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2019 оны 04 сарын 22-ны өдрийн 15 цаг 00 минут]**-аас өмнө хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2019 оны 04 сарын 22]**-ны өдрийн **[15 цаг 30 минут]**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Үгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын орлогч З.Онолбаатар, утас-89990808, санхүүгийн албаны дарга С.Цэрэнханд утас-88434025**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн

бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан / аудитын дүгнэлтийн хамт/;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн [2] жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</li> <li>2. Татварын өрийн тодорхойлолт</li> <li>3. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>4. Харилцагч банкны тодорхойлолт</li> <li>5. Бусад нэмэлт шаардлага:</li> </ol> <p>г/Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: 1.Гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэх ажилтан , ажилчдын мэргэжлийн ур чадварыг нотлох баримт бичиг/ нотриатаар баталгаажуулсан байх/ 2.Тухайн ажлыг гүйцэтгэхдээ шаардлагатай хувцас, хэрэглэл, багаж, тоног төхөөрөмжийг ашиглан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах хэрэгтэй бөгөөд үүнээс үүдэлтэй аливаа асуудал, эрсдэлийг гүйцэтгэгч дангаар хариуцах тухай баталгааг ирүүлнэ. 3.Ажлын төсөв, тооцоо 4.Иргэний хууль болон журамд заасан шаардлага хангасан Хамтран ажиллах гэрээ байгуулж ирүүлсэн байх /Гэрэлтүүлгийг гэрээнд заасан хугацаанд, шаардлагын хэмжээнд төсөвт багтаан хийгээгүй тохиолдолд хувийн хөрөнгөөрөө болон хамтран хариуцах этгээдийн нэрийг тодорхой бичсэн байх/</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p><b>10 кВ-ын ЦДШ, дэд станц барих, засварлах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага</b></p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>Авто шат буюу подьёмтой кран</b></li> <li>2. <b>Монтерын дөрөө</b></li> <li>3. <b>Цахилгаанчны багаж хэрэгсэл</b></li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газар]</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>]хаягаар ирүүлнэ.</b></p> <p>Огноо: <b>[2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[15 цаг 00 минут]</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын Тамгын газар]</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[Санхүүгийн өрөө]</b></p> <p>Огноо: <b>[2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[15 цаг 30 минут]</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[1 багцтай]</b></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтын хураангуй . Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартанд нийцсэн байна.

Нэр төрлийнд угаар	Бараа болон холбогдох үйлчилгээ	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
1.	<i>Чандмань сумын төвийн гудамжинд тавигдах гэрэлтүүлэг</i>	<p>Урд гол багийн 1-р хорьтын Арь гэгээний суваргын дээд талаас хойш Цаг уур, Тодоогийн хашаа хоёрын дундуур замын 2 талаар .....ш, сургуулийн хашааны хойд талыг дагуулан ш, цэцэрлэгийн хашаа, соёлын төвийн хашааг тойрсон хэсэгт 4ш, нийт 20ш төмөр хөлтэй, нарны батарейтай, неон гэрэлтүүлгийг зурагт заасны дагуу хоорондоо 25-30 метрийн зайнд нийт 20 ширхэг шон бүхий гэрэл суулгаж, .... ваттаас доошгүй чадалтай ЛЕД гэрлүүдийг 5-6 метрийн өндөрт, махир толгойнд бэхлэн суурилуулах ба гэрлийн тусгал нь доош чиглэсэн биш харагдах орчны талбайг их хамрахаар хийгдсэн байвал зохино. Гэрэлтүүлгийн хийх, техникийн нөхцөл авахад гарах зардлыг гүйцэтгэгч бүлэг хариуцна.</p> <p>Гэрэлтүүлэг хийхдээ гэрэлтүүлгийн кабель, батарей, ламп тэжээл болон бусад төхөөрөмжийг чанарын өндөр түвшинд суурилуулах, шонгийн бэхэлгээг зуурмаг ашиглан сайтар хийж өгсөн байна.</p> <p>Мөн албан байгууллага, хорьтуудын гудамжны гэрэлтүүлгийн шонг ашиглан богино махир иштэй, өөр дээрээ батарейтай, неон гэрэлтүүлэг нийт 50 ш-ийг байрлуулна.</p> <p>Гэрэлтүүлгийн төмөр шон нь үйлдвэрийн байна.</p> <p>Гэрэлтүүлэг хийгдэх нийт урт нь 1500 м-ээс доошгүй байх бөгөөд техникийн үзүүлэлт нь  хавсралт 1  байна</p> <p>Ажил гүйцэтгэхэд шаардагдах бүх материал нь шинэ , ашиглагдаагүй , ашиглалтын шаардлага хангасан байвал зохих ба гэрэлтүүлгийн ажлыг холбогдох дүрэм журмын дагуу мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай.</p> <p>Гудамжны эхлэл төгсгөл бүхий тус бүр 4 газарт төслийн танилцуулгыг төмөр хавтан дээр бичиж хадсан байна.</p> <p><b>Бараа нийлүүлэх эхний хугацаа:</b> <b>2019 оны 05 дугаар 01 сар</b></p> <p><b>Бараа нийлүүлэх эцсийн хугацаа :</b> <b>2019 оны 08 дугаар сарын 01</b></p>

Нийлүүлэх бараа, үйлчилгээний тоо хэмжээ, чанарын үзүүлэлт:

№	Захиалах бараа, ажил үйлчилгээ	Тоо хэмжээ  ш	Чанарын үзүүлэлт	Тайлбар
1	Гудамжны нарны зайн шонтой гэрэлтүүлэг	20	шонтой, LED гэрэлтэй, өөр дээрээ батарейтай, неон гэрэл	Чанартай, аль ч улсад үйлдвэрлэгдсэн байж болно
2	Гудамжны нарны зайн шонгүй гэрэлтүүлэг	50	Зориулалтын болон зориулалтын бус шон дээр бэхлэх боломжтой, LED гэрэлтэй, өөр дээрээ батарейтай, неон гэрэл	Чанартай, аль ч улсад үйлдвэрлэгдсэн байж болно

**Гэрэлтүүлгийн загвар, техникийн үзүүлэлт:**


Загвар	20 ватт
Хүний мэдрэмж	Бий
Нарны хавтангийн чадал	18V40W
Нарны хавтангийн нас	25 жил
Нарны батарейн хэлбэр	Литиум батарей
Нарны батарейн баталгаа	5 жил
LED дээд чадал	12V 18W
LED гэрлийн брэнд	АНУ-ын Bridgelux брэнд
Люмен (LM)	2160-2340lm
LED гэрлийн насжилт	50000 цаг
Гэрэлтэлтийн өнцөг	120 градус
Цэнэглэх хугацаа	6-7 цаг
Ажиллах хугацаа	20 цагаас илүү
Ажиллах температур (°C)	-20~+60
ССТ (к)	6500k-7000k
Шонгийн өндөр	5-6м
Гэрлийн шонгийн зай	18-20м
Их биений материал	Хөнгөн цагаан хайлш
Сертификат	ISO/CE / ROHS / IP65
Үйлдвэрийн баталгаа	2 жил
Гадна хэмжээ (мм)	920*325*43
Цэвэр жин	12кг
Хайрцагын хэмжээ (мм)	960*380*195
Хайрцаган дахь тоо шир	1 шир
Бохир жин	14.5 кг

**Гэрэлтүүлгийн загвар, техникийн үзүүлэлт:**

Загвар	20 ватт
Хүний мэдрэмж	Бий
Нарны хавтангийн чадал	18V40W
Нарны хавтангийн нас	25 жил
Нарны батарейн хэлбэр	Литиум батарей
Нарны батарейн баталгаа	5 жил
LED дээд чадал	12V 18W
LED гэрлийн брэнд	АНУ-ын Bridgelux брэнд
Люмен (LM)	2160-2340lm
LED гэрлийн насжилт	50000 цаг
Гэрэлтэлтийн өнцөг	120 градус
Цэнэглэх хугацаа	6-7 цаг
Ажиллах хугацаа	20 цагаас илүү
Ажиллах температур (°C)	-20~+60



ССТ (к)	6500k-7000k
Шонгийн өндөр	5-6м
Гэрлийн шонгийн зай	18-20м
Их биений материал	Хөнгөн цагаан хайлш
Сертификат	ISO/CE / ROHS / IP65
Үйлдвэрийн баталгаа	2 жил
Гадна хэмжээ (мм)	920*325*43
Цэвэр жин	12кг
Хайрцагын хэмжээ (мм)	960*380*195
Хайрцаган дахь тоо шир	1 шир
Бохир жин	14.5 кг



\*Хуучин загварын нарны гэрэл нь зориулалтын шон хэрэглэж байсан бол одоо ямар ч шон дээр бэхэлж болно. Энэ нь зам талбайн гэрэлтүүлэгийн зардлыг их хэмжээгээр бууруулах болно.

\* Гудамж замын гэрэлтүүлэг хийхэд заавал гэрлийн шон хэрэглэхгүйгээр байшингийн дээвэр дээр байрлуулж болно.

\* Спорт тоглоомын талбай, агуулахын хашаа, гэр хороололын гудамж, малын саравч гэх зэрэг газруудад хүссэн багана дээрээ суурьлуулан ашиглаж болно.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(**Захиалагч байгууллагын нэр**)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [**тендерт оролцогчийн нэр**], [**гэрээний нэр ба дугаар**]-ыг [**тендерийн үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.  
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр** **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**  
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлууна.  
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- |   |   |
|---|---|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.<br>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.<br>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.  |
| <b>13. Алданги</b>                          | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.                              |

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |                          |  |
|--------------------------|--|
| <b>14. Ажил дуусгах</b>  | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| <b>15. Хүлээж авах</b>   | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.   |
| <b>16. Эцсийн тооцоо</b> | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.   |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ

**төлбөр**

мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ.  Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын

	авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:



- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*